

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Гадаад хэргийн яам, Японы Васедагийн их сургууль, Хятадын Ази, Номхон далайн хүрээлэнтэй хамтран зохион байгуулж буй “Зүүн Азийн интеграци: өнөөгийн байдал, хэтийн төлөв” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал 2005 оны 7-р сарын 5-нд Гадаад хэргийн яамны хурлын танхимд боллоо. Энэхүү бага хуралд БНХАУ-ын Улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн Гадаад харилцааны хорооны гишүүн, Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн Ази, Номхон далайн судлалын хүрээлэнгийн захирал, Хятадын Ази, Номхон далайн судлалын холбооны ерөнхийлөгч, профессор Жан Юньлин, Японы Васедагийн их сургуулийн Улс төр судлал, эдийн засгийн сургуулийн профессор, “Орчин үеийн Ази судлал” төслийн удирдагч, хатагтай Казуко Мори, Хятадын Нийгмийн шинжлэх ухааны академийн Бүс нутгийн аюулгүй байдлын судалгааны төвийн орлогч захирал Лю Цинхуа зэрэг Хятад, Японы тухайн салбарын тэргүүлэх томоохон эрдэмтэд оролцож байгаа нь энэхүү хурлын ач холбогдлыг илэрхийлж байлаа.

МОНГОЛ УЛС БА ЗҮҮН АЗИ

*Г.Төмөрчулуун**

Хатагтай, ноёд оо!

Юуны өмнө Япон, Хятад, Монголын нэртэй эрдэмтэд оролцож буй энэхүү чухал уулзалтад урьсанд гүн талархлаа дэвшүүлье. Өнөөдрийн уулзалт Зүүн Азийн ард түмнүүдийн анхаарлыг татаж буй чухал асуудлуудын талаар бие биеийн байр суурь, үзэл бодлыг танин мэдэх, тулгарч буй асуудлуудын шийдлийг эрдэмтдийн түвшинд хамтын хүчээр эрж хайх, улмаар нэгдсэн ойлголтод хүрэхэд чухал ач холбогдолтой байх болно гэж итгэж байгаагаа илэрхийлье.

ЗХА-д газар зүйн байрлалын хувьд ОХУ, БНХАУ, Япон, БНАСАУ, БНСУ, Монгол Улс хамрагдах боловч Номхон далайн хойт хэсэгт оршдог, бүс нутгийн зарим оронтой старатегийн ойр харилцаатай АНУ бүс нутгийн үйл хэрэгт чухал нөлөөтэй байдаг. ЗХА-ийн нэг гол онцлог гэвэл бүс нутгийн улс орнууд нь хүн ам, газар нутгийн хэмжээ, улс төрийн тогтолцоо, хөгжлийн түвшин, байгалийн баялаг зэрэг үзүүлэлтээрээ өөр хоорондоо эрс ялгаатай байдаг. Мөн өнгөрсөн түүхээс үүдэлтэй ард түмнүүд хоорондын үл итгэлцэх байдал бүрэн арилаагүй, бүс нутагт хүйтэн дайны үеэс шийдвэрлэгдээгүй үлдсэн асуудал олон бий юм. Эдгээрийн дотроос хамгийн их эрсдэлтэй нь Солонгосын хойг, Тайвань, Япон-Хятадын, Япон-Өмнөд Солонгосын, Орос-Японы газар нутгийн маргаан юм. Мөн түүнчлэн Японд дэлхийн 2 дугаар дайнд Японы оролцоог зөвтгөсөн агуулгатай түүхийн сурах бичиг гарсаар байгаа нь Солонгос-Японы, Хятад-Японы харилцааг хурцатгах бас нэг үндэс болж

* Г.Төмөрчулуун - Гадаад хэргийн яам, доктор

байгаа юм. Хулгайлагдсан иргэдийн тухай асуудал тэртэй тэргүй ээдрээтэй Хойд Солонгос, Японы харилцааг улам хурцатгаж байна. Хятадын парламент 2005 оны эхээр “салан тусгаарлахын эсрэг хууль” гаргасан нь Хятад, Тайванийн харилцааг хүндрүүлэв.

Зүүн Хойд Азид Европынх шиг асуудлыг тайван замаар шийдвэрлэх бүс нутгийн механизм байхгүй зэрэг нь бүс нутагт итгэлцлийг бэхжүүлэх, хамтын ажиллагааг жинхэнэ утгаар нь өрнүүлэхэд бэрхшээл учруулж байна.

Монгол Улс нь Азийн орон болохын хувьд тус тивд өөрийн гэсэн байр сууриа эзлэх, Азийн орнууд, юуны өмнө хөрш зэргэлдээ орнуудтай найрсаг харилцаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлэх, хамтран ажиллах, бүс нутгийн интеграцчилал, хамтын ажиллагаанд хамрагдах нь манай гадаад бодлогын тэргүүлэх зорилтын нэг болж байдаг. Энэ талаар Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд “Монгол Улсын гадаад бодлогын нэг үндсэн чиглэл бол Азийн бүс нутагт байр сууриа бататгаж, эндхийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох явдал мөн. Энэ зорилтын хүрээнд Ази, Номхон далайн чиглэл, түүний дотор Зүүн Хойд Ази, Төв Азийн чиглэлд түлхүү анхаарна... Бүс нутгийн интеграцид орох нөхцлийг юуны өмнө түүнд хамаарч буй улс орнуудтай хоёр талын харилцааг өргөтгөн хөгжүүлэх замаар бүрдүүлнэ” гэж заасан болно.

Үзэл баримтлалын дээрх заалтыг хэрэгжүүлэх талаар өнгөрсөн 11 жилд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

- Монгол Улс 1998 онд АСЕАН-ы Бүсийн Чуулгад элсэж үйл ажиллагаанд нь оролцож ирэв. Энэ нь Монголын зүгээс АСЕАН-ы орнуудтай ойртон ажиллахад чухал алхам болж, Азид байр сууриа бэхжүүлэхэд чухал алхам болжээ.

- Монгол Улс 2004 онд АСД /Азийн хамтын ажиллагааны яриа хэлцээ/-нд нэгдэн орсон. АСД-ийн сайд нар нарын хэмжээний энэ оны 4 дүгээр сарын уулзалтад манай Гадаад хэргийн сайд оролцсон.

- 1991 онд Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны Зөвлөл /ПЕКК/-д элсэн орох хүсэлтээ гаргасан бөгөөд улмаар 1997 онд ПЕКК-ийн Үндэсний Хороо буюу МонПЕКК-ийг 1997 онд байгуулсан. 2000 онд түүний хавсарга гишүүний статустай болсон. Өдгөө энэ статусыг жинхэнэ гишүүний статус болгох зорилт тулгарч байгаа.

- Мөн Солонгосын хойгийн асуудлаархи 6 талт яриа хэлэлцээний албан бус суваг болох Зүүн хойд Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээ /NEACD/-д оролцохоор нэлээд идэвхтэй үйл ажиллагаа явуулсан боловч сүүлийн үед Хойд Солонгос энэ хэлэлцээнд оролцохгүй байгаагаас үүдэн манайхыг өнгөрсөн 4 дүгээр сард Сөүлд болсон уулзалтаар элсүүлэх асуудал хойшлогдсон. Хойд Солонгос 6 талт

хэлэлцээнд эргэж оронгуут Монголыг энэхүү албан бус сувагт элсүүлнэ гэж Америкийн тал мэдэгдээд байгаа болно.

- Монгол Улс 2003 онд АПЕК-т элсэх өргөдлөө гаргасан боловч 2007 он хүртэл моратори тогтоосон тул түүнд элсэх ажил зогсонги байдалд ороод байгаа болно.

- Монгол Улс АСЕМ-д элсэх талаар мөн хөөцөлдөн ажиллаж байгаа бөгөөд энэ оны 5 дугаар сард Киотод болох Гадаад хэргийн сайд нарын уулзалтаар АСЕМ-ийн гишүүнчлэлийн асуудлыг ярьж холбогдох журмыг гаргахыг хүлээнэж байгаа.

- Ази дахь өөр нэг чухал тогтолцоо бол 1997 оноос дүр төрхөө олж эхэлсэн АСЕАН+Хятад, Япон, БНСУ-ыг оролцуулсан Зүүн Азийн хамтын нийгэмлэг юм. Энэ нийгэмлэгийн дээд хэмжээний уулзалт энэ оны сүүлээр Куала Лумпурт болох бөгөөд түүнд оролцох асуудлыг холбогдох талуудад тавихад тэрээр Монгол, АСЕАН-ы хоорондын худалдааны хэмжээ уг нийгэмлэгт оролцоход хангалтгүй байгаа гэсэн тайлбарыг АСЕАН-ыхан хэлж байгаа. Зүүн Азийн хамтын нийгэмлэгт орох улс орон АСЕАН-ы орнуудын хоорондын Найрамдал, хамтын ажиллагааны Гэрээнд нэгдэн орсон байх, АСЕАН-тай хамтран ажиллах бүрэн хэмжээний түншүүд байх, АСЕАН-ы орнуудтай улс төр, худалдаа, эдийн засгийн өргөн харилцаатай, эдгээр асуудлаар олон төслүүд хэрэгжүүлсэн байх ёстой гэсэн урьдчилсан болзлуудыг хангасан байх шаардлагатай гэж байгаа болно. Ийм түншүүдийн тоонд Австрали, Канад, Европын Холбоо, Шинэ Зеланд, АНУ, БНХАУ /1996/, Энэтхэг /1996/, БНСУ /1991/, ОХУ/ 1996/, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр /1997/ ордог.

- НҮБ-ын ХХ-өөс санхүүждэг Түмэн голын төсөлд оролцож ирсэн

- ЭСКАТО-ийн шугамаар зарим төсөлд тухайлбал Азийн авто сүлжээ /дэлгэрүүлэх/

- Үүний зэрэгцээ CSCAP, ЗХА-ийн эдийн засгийн асуудлаар жил бүр Японы Нийгатад болдог бага хурал зэрэг 2 дахь сувгийн үйл ажиллагаанд манайх тогтмол оролцож ирсэн.

Монгол Улс Зүүн Азийн хамтын нийгэмлэгт нэгдэн орох хэд хэдэн чухал үндэслэл байгаа тухай та бүхэнтэй саналаа хуваалцъя.

- Монгол Улс өнгөрсөн хугацаанд АСЕАН болон Япон, БНХАУ, БНСУ-тай найрсаг харилцаа хөгжүүлж ирэв.

- Монгол Улс хөрш зэргэлдээ бөгөөд бүс нутгийн орнуудтай улс төрийн болон газар нутгийн маргаангүй цорын ганц улс юм.

- Дотооддоо улс төрийн хувьд тогтвортой, энх тайванч гадаад бодлоготой, эдийн засаг нь хөгжиж байгаа Монгол Улс бүс нутагт тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй юм.

- Монгол Улс уул уурхай, ХАА, аялал жуулчлалын салбарт Зүүн Азийн улс орнуудтай бие биенийгээ нөхсөн хамтын ажиллагаа явуулах бүрэн үндэстэй.

Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд Монгол Улсыг Зүүн Азийн интеграцид оролцуулах улс орны дотоод эдийн засгийн таатай нөхцөл алгуур бүрэлдэж байгааг хэлэх ёстой. 1993-2003 онд эдийн засгийн бодит өсөлт жилд дунджаар 3.3 хувьд хүрч, 2004 онд энэ үзүүлэлт 10.6 хувь болж өссөн. Инфляцийн түвшин 1995 онд 53.1 хувь байсан бол 1998-2003 онд жилд дунджаар 10.0 хувиас хэтрээгүй болно.

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг илэрхийлэх нэг гол үзүүлэлт болох төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сүүлийн 3-4 жилд үндсэндээ тогтвортой байлаа.

Иргэд аж ахуйн нэгжийн банкинд итгэх итгэл сэргэж, банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ, эдийн засагт дэмжлэг үзүүлэх эзэлийн эх үүсвэр ихээхэн нэмэгдсэн. Банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэн гадаадын хөрөнгө оруулалттай банкууд шинээр бий болов.

Өдгөө манай дотоодын нийт бүтээгдэхүүний 28,8 хувийг худалдаа, 20,0 хувийг хөдөө аж ахуй, 15,1 хувийг тээвэр, 9,5 хувийг уул уурхай, 6 орчим хувийг боловсруулах үйлдвэрийн салбарууд бүрдүүлж байна.

Тус орны хувьчлалын процесс болон бүтцийн өөрчлөлт шинэчлэлтийн үрээр ДНБ-ний 80 орчим хувийг хувийн хэвшлүүд бүрдүүлж байна.

Монгол Улс 1997 онд ДХБ-д гишүүнээр элссэнээр олон талт худалдааны зарчмуудыг хөгжил дэвшлийнхээ хөшүүрэг болгон сонгосон. Гадаад худалдаа ДНБ-д 90-110 хувийг эзэлж байдаг нь манай улсын эдийн засаг гадаад худалдаанаас ихээхэн хамааралтай байдгийн жишээ юм. Иймээс ч далайд гарцгүй Монгол шиг газар зүйн онцгой байршилтай орны хувьд худалдааны бодлогоо оновчтой, зөв тодорхойлон хэрэгжүүлэх нь туйлын чухал гэдгийг Засгийн газар ойлгож, худалдаагаа илүү чөлөөтэй, нээлттэй болгох бодлого баримталсан нь эдийн засагт нааштай нөлөөлж байна.

Гадаад худалдааны бараа эргэлт 2004 онд 1.9 орчим тэрбум ам.долларт хүрч, экспортын хэмжээ 855 сая ам. доллар, импорт 1 тэрбум 10 сая ам.доллар болсон байна. 1995 онд гадаад худалдааны эргэлт 937,2 ам.доллар байсан. Хэрэв 1990-ээд оноос өмнө Монгол Улсын гадаад худалдаанд ЗХУ болон Зүүн Европын орнууд 90 гаруй хувийг эзэлж байсан бол газар зүйн чиглэлд эрс өөрчлөлт гарч, өнөөдөр худалдааны түнш орнуудын тоо 80 гаруйд хүрч, гол түншүүдэд БНХАУ, ОХУ, АНУ, ЕХ, БНСУ, Япон зэрэг орон багтаж байна.

Гадаад худалдааны талаар ойрын жилүүдэд баримтлах бодлого нь гадаад худалдааны эргэлтийн хэмжээг 2008 оны эцэс гэхэд 2003 оны түвшингээс 1,5 дахин өсгөх, экспортын эх үүсвэрийг 2006 оноос жил бүр 100-150 сая ам.доллараас доошгүйгээр нэмэгдүүлэх, ДНБ-д экспортын эзлэх хувийн жинг 60-аас доошгүй хувьд байлгах зорилт тавьж байна.

Гадаад дотоодын бүх эх үүсвэрийг оролцуулан тооцсоноор 2004 онд нийт 445 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Энэ нь өнгөрсөн оныхоос 4.1 хувиар их байгаа юм. Үүнээс гадаадын шууд хөрөнгө оруулалт 1990-1996 онд 164,5 сая ам.доллараас 1997-2003 онд 950,2 сая ам. доллар болж бараг 5,8 дахин өссөн байна.

Хөрөнгө оруулалтын илүү таатай эрх зүйн орчин бүрдүүлэхэд ач холбогдол өгч, Хөрөнгө оруулалтын тухай 1993 оны хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан нь хөрөнгө оруулалтыг татах болон хамгаалахад чухал хөшүүрэг болсон. Цаашид бид гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2008 оны эцэс гэхэд одоогийнхоос 2,2 дахин нэмэгдүүлэх зорилгоор импортын гаалийн тарифын оновчтой, уян хатан бодлого явуулах, худалдааг цаашид хөнгөвчлөх, илүү чөлөөтэй болгох арга хэмжээ авах болно.

Зүүн Азийн хамтын нийгэмлэг нь бүс нутгийн аль нэг улс орны хувьд хаалттай бус, нээлттэй байгууллага байх ёстой гэж бид үзэж байгаа. Зүүн Азийн хамтын нийгэмлэг нь бүс нутгийн том, жижиг бүх улс орнуудын хувьд нээлттэй байж гэмээж нь сая Зүүн Азийн улс түмний цэцэглэн хөгжих, хамтран ажиллах их үйлсэд өөрийн бодитой хувь нэмрийг оруулна гэж бид найдаж байна.